



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 463

Чойбалсан

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.7, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5, "Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 3.2.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 18-1/01 тогтоолоор батлагдсан аймгийн 2024 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөний 1.3 дахь заалт, "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 19/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жудо бөхийн тэмцээн зохион байгуулахад 20,000,000 (хорин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлж, төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.


2. Дэмжлэгт шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 2.49 дэх Жудо бөхийн тэмцээн зохион байгуулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (П.Бат-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Биеийн тамир, спортын газартай байгуулах орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх гэрээг боловсруулан батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т даалгасугай.

4. Тэмцээнийг чанартай зохион байгуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг олон нийтэд танилцуулж ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газар (Б.Чимэддорж)-т даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ш.Ёл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

212401116

Аймгийн Засаг даргын 2024 оны
01 дугаар сарын 28 -ны өдрийн
№63 дугаар захирамжийн хавсралт



МОНГОЛ УЛСЫН СПОРТЫН МАСТЕР БОРЯГИЙН ХАТАНБҮҮВЭЙ,
ТАЛЫНБҮҮВЭЙ НАРЫН НЭРЭМЖИТ ЖУДО БӨХИЙН ӨСВӨР ҮЕИЙН ЗҮҮН
БҮСИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв өртөг (төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн
1	Медальт байранд шалгарсан багийн шагналын зардал	3,600,000	Тамирчдын тоо	500
2	Медаль, өргөмжлөл, цом, хулдаасан хэвлэл, мандат хийлгэх зардал	10,535,000	Тамирчдын тоо	500
3	Тэмцээний албаны ажилчид, шүүгчдийг байрлуулах зочид буудлын зардал	1,800,000	Албаны ажилчид, шүүгчдийн тоо	30
4	Тэмцээний шүүгчдийн хоолны зардал	2,990,000	Шүүгчдийн тоо	12
5	Зохион байгуулалтын зардал	575,000	Тамирчдын тоо	500
6	Хэвлэл мэдээллийн зардал	500,000		
НИЙТ ДҮН		20,000,000		

---oOo---